



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журам
батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10, 43 дугаар зүйлийн 43.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хөдөлмөрийн дотоод журам”, журмыг дагалдан гарах маягтуудыг хавсралтаар баталсугай.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг нийт албан хаагчдад танилцуулж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Жавхлан/-т, тус журмыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Б.БОЛОР-ЭРДЭНЭ

990767